



# УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖ ГЭЖ ЮУ ВЭ?



**Уул уурхайн бүтээгдэхүүний бирж** нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй, ил тод, хараат бус, өрсөлдөөний үндсэн дээр зохион байгуулж, арилжааны гэрээ, хэлцлийг зуучлах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг байгууллага юм.

## АРИЛЖААНД ОРОЛЦОГЧИД



Харилцагч /худалдагч,  
худалдан авагч тал/



Зуучлагч  
/брокер/



Тооцооны  
байгууллага



Төлбөрийн  
банк



Бирж



Шинжилгээний  
лаборатори



Агуулах, терминал



Тээвэр, ложистикийн  
компани

## БИРЖЭЭР АРИЛЖААЛДАГ БҮТЭЭГДЭХҮҮН



НҮҮРС



ТӨМӨР



ХАЙЛУУР ЖОНШ

## ГЭРЭЭНИЙ ТӨРӨЛ



**Спот гэрээ**– Бүтээгдэхүүнийг арилжааны үр дүнд тогтсон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэхээр тохиролцох



**Форвард гэрээ**–Тогтоосон хугацаанд, тохиролцсон үнэ, нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр тохиролцох

## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЗААВАР

### 1 Нүүрсний спот гэрээний дуудлага арилжааны системд бүртгүүлэх:



[www.comex.mse.mn](http://www.comex.mse.mn) системд  
хэрэглэгчээр бүртгүүлэх



Байгууллага худалдан авах санал  
гаргагчаар бүртгүүлэх



Тухайн өдрийн арилжааны нийт үнийн  
дүнгийн 10 хувийг дэнчингээр байршуулах



Баримт бичгийн бүрдэл  
баталгаажсан төлөвтэй болох

### 2 Арилжаа явагдах үйл явц:



Бирж арилжааг ажлын өдрүүдэд 10:00–17:00 цагийн хооронд зохион  
байгуулна.



Уул уурхайн бүтээгдэхүүний гэрээг худалдагчаас ирүүлсэн доод үнээс  
эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэйгээр арилжина.



Худалдан авагч, эсхүл брокерын оруулсан хамгийн өндөр үнийн  
саналаар хэлцэл хийгдсэнээр тухайн арилжаа дуусгавар болно.



Бирж нь арилжааг ил тод зохион байгуулж, бүтээгдэхүүний үнэ, гэрээний  
мэдээллийг арилжаанд оролцогчид болон олон нийтэд үнэн зөв, түргэн  
шуурхай хүргэж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.